



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 СУУРЬ БОЛОВСРОЛ



ТҮҮХ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:


Сурагчийн нэр:

Сурагчийн код:

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

1. Доорх он тооллын шугамыг ашиглаж “Homo sapiens” хэзээ үүссэнийг тооцоолоорой.



- A. 2.400.000 – 1.600.000 жилийн өмнө
C. 100.000 жилийн өмнө

- B. 1.500.000 – 300.000 жилийн өмнө
D. 200.000 – 30.000 жилийн өмнө

2. Дараах зургийг ажиглаад асуултад хариулаарай.



Үүрсэн болон барьсан багаж зэвсгээс нь дүгнэвэл энэ хүн аль үед амьдарч байсан бэ?

- A. Палеолитын үе
C. Неолитын үе

- B. Мезолитын үе
D. Хүрэл зэвсгийн үе

“Өтци” хөндийгөөс 1991 онд олдсон “цасан доорх хүн” түүнийг сэргээсэн байдал

3. Эртний хүмүүс өөрсдийн амьдралд болсон онцлог үйл явдлыг модны холтос, үйс арьс чулуу зэрэг дээр бичиж тэмдэглэж үлдээснийг түүхийн ямар эх сурвалжид хамааруулан үздэг вэ?

- A. Бичгийн B. Аман C. Эд өлгийн D. Биологийн

4. Хуучин чулуун зэвсгийн үед эрэгтэйчүүд ямар ажлыг ихэвчлэн хийдэг байсан бэ?

- A. Галаа манах B. Үр жимс түүх
C. Ан гөрөө хийх D. Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх

5. Дараах зурагт ваар хийх ямар аргыг дүрсэлсэн байна вэ?



- A. Савх мод ашиглах арга
B. Ороомог арга
C. Хэв ашиглах
D. Эргэдэг хүрдээр

6. Малчид 6-8 дугаар сард ихэвчлэн голын эрэг эсвэл дэнж газар буудаг. Энэхүү газрыг нь юу гэж нэрлэдэг вэ?

- A. Өвөлжөө
B. Хаваржаа
C. Намаржаа
D. Зуслан

7. Монгол орны төв болон дорнод хэсэгт элбэг тохиолддог оршуулгын байгууламж аль нь вэ?

- A. Хиргисүүр
B. Дөрвөлжин булш
C. Хадны оршуулга
D. Буган хөшөө

8. Түүвэр олдворыг хэлбэр, хийц, зориулалтаар нь юу гэж ангилдаг вэ?

- A. Аж ахуйн, дайн байлдааны, гоёл чимэглэлийн буюу урлагийн холбогдолтой
B. Аж ахуйн, шашны хийцтэй, гоёл чимэглэлийн буюу урлагийн холбогдолтой
C. Гар урлал, дайн байлдааны, гоёл чимэглэлийн буюу урлагийн холбогдолтой
D. Гар урлал, шашны хийцтэй, гоёл чимэглэлийн буюу урлагийн холбогдолтой

9. Эртний Шүмер, Вавилон, Аккадын газар тариалан, соёл иргэншил ямар мөрний хөндийд үүссэн бэ?

- A. Амазон мөрний хөндий
B. Хоёр мөрний хөндий
C. Ижил мөрний хөндий
D. Ганга мөрний хөндий

10. Эртний хүмүүс суурин амьдралд шилжихэд нөлөөлсөн гол аж ахуй юу вэ?

- A. Мал аж ахуй
B. Ан гөрөө
C. Газар тариалан
D. Түүвэрлэх аж ахуй

11. Эртний иргэншлүүдэд тариалангийн газар хэний мэдэлд байсан бэ?

- A. Боол
B. Ард түмэн
C. Язгууртан
D. Худалдаачид

12. Зэсийг хэзээ анх хэрэглэж эхэлсэн бэ?

- A. НТӨ 8000 – НТӨ 7000 онд
B. НТӨ 6000 – НТӨ 5000 онд
C. НТӨ 4500 – НТӨ 4000 онд
D. НТӨ 3000 – НТӨ 1200 онд

13. Эртний Шүмерүүдийн зохиосон Дүрс бичиг буюу шаантаг бичиг аль вэ?



14. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу.

Эртний Египетчүүд фараонд зориулж барьдаг байжээ.

- A. дөрвөлжин булш B. пирамид C. хэрэм D. хиргисүүр

15. Тигр, Евфрат мөрөн хаанаас эх авч, хаашаа цутгадаг вэ?

- A. Умард Африкийн тэгш өндөрлөгөөс эх авч, Газар дундын тэнгист цутгадаг.
B. Хиндикуш, Гималайн нуруунаас эх авч, Арабын тэнгист цутгадаг.
C. Төвөдийн тэгш өндөрлөгөөс эх авч, Шар тэнгист цутгадаг.
D. Бага Азийн өндөр уулсаас эх авч, Персийн буланд цутгадаг.

16. Энэтхэгийн кастын тогтолцоонд хамгийн дээд эрх мэдэлтэй хэсгийн санваартнуудыг юу гэж нэрлэдэг байсан бэ?


- A. Шудра B. Вайши C. Брахман D. Кшатри

17. Цэгийн оронд тохирох утгыг нөхөж бичээрэй.

Спарт нь (1)..... дэглэмтэй (2)..... эрх мэдэлд тулгуурласан хот улс байлаа.

- A. 1.Ардчилсан, 2.олонхын B. 1.Цэргийн, 2. олонхын
C. 1.Ардчилсан, 2.цөөнхийн D. 1.Цэргийн, 2. Цөөнхийн

18. Зургийг анхааралтай ажиглаад дасгалыг гүйцэтгээрэй. Эртний Грекийн “Дайны бурхан Арес” аль вэ?



19. Сяньби улсыг хэн үндэслэн байгуулсан бэ?

- A. Мугулюй B. Таньшихуай C. Пэйло D. Моюнчур

20. Цэгийн оронд тохирохыг сонгоно уу.
Жужаны (Нирун) захиргаанд байсан Алтайн бослого гарган, 555 онд Жужан улсыг мөхөөжээ.
- A. Хүннүчүүд B. Сяньбичууд C. Түрэгүүд D. Уйгурууд
21. Хүннү гүрний цаг уур, газар нутгийн онцлогийг зөв тодорхойлсон нь аль вэ?
- A. Эх газрын чийглэг, эрс тэс уур амьсгалтай, нам дор газар, далайн эрэгт олон арлаар хүрээлэгдсэн
B. Эх газрын чийглэг, дулаан уур амьсгалтай, нам дор газар, ихэнх газар нь ой модоор хүрээлэгдсэн.
C. Эх газрын хуурай, дулаан уур амьсгалтай, өндөр уулс, далайн эрэгт байрладаг.
D. Эх газрын хуурай, эрс тэс уур амьсгалтай, өндөр уулс, хээр тал, говь цөл хосолсон.
22. Хүннү улсаас үеэс үүсэлтэй монголчуудын өнөө цагт ч тэмдэглэдэг баяр аль вэ?
- A. Цэргийн баяр B. Тусгаар тогтнолын баяр
C. Эрийн гурван наадам D. Шинэ жил
23. НТӨ 198 онд Хүннү болон Хан улс хоёр энх ургийн гэрээ байгуулжээ. Уг үйл явдал хэддүгээр мянганы, хэддүгээр зуунд харьяалагдах вэ?
- A. НТ I мянганы I зуунд B. НТӨ II мянганы III зуунд
C. НТӨ I мянганы II зуунд D. НТ II мянганд II зуунд
24. Уйгар улс 745 онд байгуулагджээ. Тэгвэл үйл явдал одоогоос хэдэн жилийн өмнө болсон бэ?
- A. 2768 жилийн өмнө B. 1378 жилийн өмнө
C. 2668 жилийн өмнө D. 1278 жилийн өмнө
25. НТӨ 198 оны гэрээгээр Хүннү ба Хань улсын хил хаагуур тогтсон бэ?
- A. Урт Цагаан хэрэм B. Ордосын Бор тохой
C. Шар мөрөн D. Хянганы нуруу